

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН ОРЧИН

С.БАЗАРПҮРЭВ

Доктор. профессор. МУИС, ШУС, Нийгэмийн Ухааны Салбар.

Улс Төр Судлалын Тэнхим

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Докторант

Key words: investment, politics, policy, political stability

Abstract: Mongolia has transition to democratic society for twenty five years. This time, one of the work with related to liberation politic and economy. Such as, adoption of law "Foreign Invest" in 1993. This law in over twenty years, bring to significant in Mongolian politic and economy. Because, it is give lot of results of investments and new technologies in development of civil, entity and transaction of communication of marketplace. Since 2008, foreign direct investment grow up is related to activation of mining field. But latest two years, foreign direct investment decrease is to attract attention of politicians and researchers. I will be review of whether is the reason of FDI declined from Mongolian instability political environment or Chinese weakening economic growth slow condition is due to in the mining sector?

Монголын улс төрийн орчин

Улс төрийн орчин гэдэгт хууль, засгийн газрын агентлаг, лобби бүлэг зэргийг багтаан авч үздэг байна. Эдгээр нь тухайн нийгэм дэх байгууллага, субъектэд нөлөөлж тэднийг дэмжиж, хязгаарлаж чаддаг. Засгийн газрын үйл хэрэг нь компанийн, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлдөг ба орон нутгийн, бус нутгийн, үндэсний, олон улсын түвшний үйл хэрэг байж болдог байна. Бизнес эрхлэгчид болон менежерүүд засгийн газрын үйл ажиллагаа нь тэднийг бизнес, компанид хэрхэн нөлөөлөх вэ гэдэгт өндөр хариуцлагатай хандаж улс төрийн орчинд онцгой анхаарал тавьдаг¹.

Улс төрийн тогтвортой байдал нь тухайн улсын макро эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа, бизнесийн орчинд чухал нөлөөтэй. Улс төрийн тогтвортой байдал, засаглалын үйл ажиллагаатай улс төрийн эрсдэл байнга холбогддог. Улс төрийн тогтвортой байдал хөгжжик буй улсуудад ГШХО-ын дотогшлох ургалыг татах сайн талтай. Улс төрийн систем өөрчлөгдхөх, солигдох, засгийн газрын тогтвортой байдал нь уле төрийн эрэдлийг бий болгож дотоодын болон ГШХО-г бууруулах өндөр магадлалтай. Хэрвээ улс төрийн тогтвортой байдал тааруу байвал гадаад хөрөнгө оруулагчид бизнесээ хөгжүүлэх орчин баталгаатай, таатай байна гэдэгт эргэлзж эхэлэг. Монгол улсын хувьд Улс төрийн тогтвортой байдлын индекс 2007 онд 4.0 байсан бол 2009 онд 6.1 болж 83-р байранд орж индекс нэмэгдсэн нь улс төрийн эрсдэл нэмэгдэж улс төрийн тогтвортой байдал буурсан гэсэн үг².

Монгол улс 1990 оноос ардчилсан засаглалтай улс болж хүмүүлэлг, иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилго тавьж үүнийгээ Үндсэн хуулиндаа тусгаж өгсөн. Монгол улс төрийн засаглалтын хувьд нэг танхимт парламенттай бүгд найрамдах улс. Төрийн тэргүүн нь ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүн нь ерөнхий сайд, хууль тогтоох эрхтэй төрийн эрх барих дээд байгууллага нь Улсын Их Хурал, түүнийг 4 жилийн хугацаатайгаар сонгодог. 1992 онд Шинэ Үндсэн хуулийг баталснаар УИХ-ын сонгуулийг ардчилсан замаар явуулж эхэлсэн. 1992-2008 оны хооронд сонгууль мажоритари системээр явагдаж байсан. Дээд шүүхэд улс төрийн 22 нам бүртгэлтэй ч парламентын 76 суудлыг хоёр нам /АН, МАН/ хувааж авдаг, хааяа 1-2 суудлыг жижиг гуравдагч нам авдаг хоёр намын тогтолцоог бий болгосон. 2012 оны парламентын сонгуульд пропорциональ хэлбэрийг оруулж нийт суудлын гуравны нэгийг пропорционалиар, гуравны хоёрыг мажоритари хэлбэрээр сонгохоор болсон. Монгол улсын сонгуулийн тухай хуулийн /2011 оны 12-р сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/ нэгдүгээр бүлгийн

¹<http://www.businessdictionary.com/definition/political-environmental.html#ixzz3LhzlIVYw>

²http://viewswire.eiu.com/site_info.asp?info_name=social_uprest_table&page=noads&rf=0

дөрөвдүгээр зүйлд 4.9. Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойгоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно³ гэж заасан байдаг. Монгол улсын Үндсэн хуулинд заасны дагуу Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ, Монгол улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцэж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ. Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно⁴. Засгийн газрыг УИХ-д олонх⁵ болсон нам, эвслээс Ерөнхийлөгчтэй зөвшилцөн санал болгосны дагуу УИХ-аас томилдог.

1992 оноос хойш УИХ-ын сонгуульд Ардчилсан Нам 1996, 2012 онуудад олон суудал авч эвслийн засгийн газар байгуулсан. Монгол Ардын Нам 1992, 2000, 2004, 2008 онуудад ялалт байгуулж олонх болж байсан.

2014 оны 11-12-р сард байгуулагдаж байгаа “Шийдлийн засгийн газар” нь 16 яам, 19 сайдтайгаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хийхээр болж байна. 2012 оны УИХ-ын сонгуулиар Ардчилсан нам олон суудал авч “Шинэчлэлийн засгийн газар” нэртэйгээр засгийн эрхийг хоёр жил гаруй хугацаанд барьсан. Энэ хугацаанд 15 яам, 19 сайдтайгаар үйл ажиллагаагаа эрхэлж байсан.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг⁶ хэлнэ гэж Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийн 3.1.1-д заасан байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад өөрийн бизнесээ өргөжүүлэн тэлэх, түүнээсээ ашиг олох зорилготой гадаадын орноос шууд орж ирж байгаа хөрөнгө оруулалтыг, мөн биет болон биет бус хөрөнгө гадаад орноос дотоодод орж ирээд зогсохгүй баялагийг бий болгох зорилготой, үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих явцыг хамруулан ГШХО гэж ойлгож болно. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийн 3.1.3-д “гадаадын хөрөнгө оруулагч” гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж байгаа гадаадын хуулийн этгээд, хувь хүн/Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьялалгүй хүн, түүнчлэн гадаад Улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн/-ийг⁷ хэлнэ гэж тодорхой заасан. Хөрөнгө оруулалт нь Монгол Улсад дараах хэлбэрээр хэрэгждэг.

- хөрөнгө оруулагч дангаараа болон бусад хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах;
- хөрөнгө оруулагч хувьцаа, орийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах;
- компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх;
- концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах;
- санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрний хөрөнгө оруулалт хийх;
- хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр⁸.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь 3 хэсгээс бүрдэнэ:

- Хувьцаа эээмших- Гадаадын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжийн хувьцааг худалдаж авах,

³ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2011 он

⁴ Монгол Улсын Үндсэн Хууль, 1992 он

⁵ Монгол Улсын Их Хурлын тухай хууль УБ 2006 он, УИХ-ын тухай хуулийн 8 дугаар зүйла Улсын Их Хурал дахь олонхи ба цөөнхийг тодорхойлсон байна. УИХ-ын тухай хуулийн 8.1-д Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийн бүлгийг Улсын Их Хурал дахь олонх гэнэ гэж заасан байдаг. 2012 оны УИХ-ын сонгуулиар Ардчилсан нам олон суудал авсан болоч “олонх” болж чадаагүй.

⁶ Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он

⁷ Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он

⁸ Хөрөнгө оруулалтын тухай хууль, нэгдүгээр бүлэг тавдугаар зүйлийн 5.1.1.-5.1.6, 2013 он

- Ашгаас дахин хөрөнгө оруулах- Гадаадын хөрөнгө оруулагчид ноогдох ашгийг хуваарилахгүйгээр, эсвэл гадаадын хөрөнгө оруулагч руу шилжүүлэхгүй эргүүлж оруулсан ашиг,
- Компани доторх зээл эсвэл өөрийн шилжүүлэг- Шууд хөрөнгө оруулагч болон харьяа компанийн хооронд хийгдэх урт болон богино хугацааны зээл болон зээлтэг⁹

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг өөрийн оронд оруулах гэж улс орнууд их хүч чармайлт гарган санаа тавьдаг. Энэ ажлыг амжилттай хийж гадаадын хөрөнгө оруулалтыг өөртөө татаж буй орнуудад АНУ, БНХАУ, Өмнөд Солонгос өрдог. Өнөөдөр дэлхий дээр гадаадын шууд хөрөнгө оруулалт нэрийн дор триллион гаруй ам доллар эргэлдэж байна. Үүний 50 орчим хувийг хөгжингүй орнууд өөртөө татан авч байршуулдаг байна. Хөрөнгө оруулагчдыг хэр их татаж чадна тэр хэмжээнд тухайн орон хөгжих нөхцөл боломж нэмэгдэнэ. Хятадын эдийн засгийн хөгжлийн загвар Гадаадын шууд хөрөнгө оруулалт том байр суурь зээлдэг. Солонгос улсын хувьд ГШХО-д их анхаарч үздэг. Жишээ нь, “Гадаадын хөрөнгө оруулалтыг татах шинэ бодлого” зарлаж БНСУ –ын хөрөнгө оруулалтын орчин олон улсын түвшинд хэрхэн зохицож байгаа, хөрөнгө оруулалтад ямар шаардлага тавьж байгаа болон хэрхэн бүртгэх, банкуудтай хэрхэн харьцах зэргийг дэлгэрэнгүй тайлбарлаж сурталчилдаг.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт ямар нэгэн эргэн төлөх өр үүсгэхгүйгээр гадаад валуутыг эдийн засагтаа татан оруулж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинэ технологи үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг олон боломжийг нээж өгдөг.

Монгол улс гадаадын хөрөнгө оруулалтад зах зээлээ нээсэн цагаас 2013 оны 10-р сарын 31 едрийн байдлаар дэлхийн 112 орны 12,764¹⁰ гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүртгэгдэж, 14 гаруй тэрбум ам.долларын шууд хөрөнгө¹¹ оруулжээ.



ГШХО-н өроихий чиг хандлага нь сүүлийн 10 жилд өссөн, 2011, 2012 онуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт үлмэж хэмжээгээр нэмэгдсэн. 2007 онд ГШХО-н хэмжээ 0.5 тэрбум ам.доллартай тэнцүү байсан бол 2012 онд буюу таван жилийн дараа монгол улсад нийтдээ 4.4 тэрбум ам.доллар болж 9 дахин нэмэгдсэн. Үүний 90 гаруй хувийг уул уурхайн салбар дангаараа эзэлж байгаа юм. Ялангуяа Оюу Толгой төслийн бүтээн байгуулалтын үеийн хөрөнгө оруулалт голлох хувийг эзлэж байсан.

⁹ Н.Батсайхан, Гадаадын шууд хөрөнгө оруулалт, 2002 он

¹⁰ U.S. Embassy in Ulaanbaatar Mongolia, 2014 Mongolia Investment Climate Statement, 7/28/2014


¹¹ U.S. Embassy in Ulaanbaatar Mongolia, 2014 Mongolia Investment Climate Statement, 7/28/2014

Гэвч сүүлийн хоёр жилийн дотор 2.4 тэрбум амдоллараар буурсан байна. Энэ огцом буурах болсон шалтгаан нь нэг талаараа Оюу Толгойн ил уурхайн бүтээн байгуулалт дууссантай холбоотой. Мөн БНХАУ –н эдийн засгийн өсөлтийн сааралтын улмаас худалдан авах эрэлт буурч Монгол улсын коксжих нүүрсний экспортод хүчтэй нелөө үзүүлсэн зэрэг эдийн засгийн шалтгаануудтай. Гэвч негee талаас хамгийн чухал нелөөтэй нь улс төрийн тогтвортой байдал, хууль эрхзүйн тогтвортой бус орчин юм. Жишээ нь, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалт хийх тухай хуулийг /2012 оны 5-р сар/ батлаад буцаан хүчингүйд тооцсон. Уг хуулийн хоёрдугаар бүлгийн 5.1-д Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндсэн орлогыг бүрдүүлэх, үндсэн аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой дараах салбарыг үндсэн аюулгүй байдалд стратегийн ач холбогдол бүхий салбар гэнэ: 5.1.1.эрдэс баялаг; 5.1.2.банк, санхүү; 5.1.3.хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо гэж заагаад 5.2.Засгийн газар шаардлагатай гэж үзсэн салбарыг стратегийн ач холбогдолтой салбарт хамааруулах асуудлыг тухай бүр нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ. Дээрх заалт нь гадаадын хөрөнгө оруулагчдад таагүй заалт болсон.

Мөн Ашигт малтмалын тухай хуулинд 2012 оны 12-р сард нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ хуульд хэсэгчлэн нэмэлт өөрчлөлт оруулсан, бүлгийн зүйлүүдийг бүтнээр нь хассан олон тохиоддол байна. Жишээ нь, 3-р бүлгийн 23-р зүйл Ашигт малтмалын өмнөх үйл ажиллагаа, 4-р бүлгийн 29-р зүйл Хөрөнгө оруулалтын гэрээ, 30-р зүйл Хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах, 6-р бүлгийн 47-р зүйл Тутгээмэл тархтаатай ашигт малтмалын нөөц ашигласны төлөөр, 10-р бүлгийн 65-р зүйл Хөрөнгө оруулалтын гэрээтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх¹² тухай зүйлүүд бүхлээрээ хасагдсан байна.

Энэ мэт хуулийг удаа дараа батлан хүчингүйд тооцох, нэмэлт өөрчлөлт оруулах нь гадны хөрөнгө оруулагчдын монгол улсад итгэх итгэл үнэмшил буурах, хууль эрх зүйн баталгаагүй байдлыг бий болгож байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг орноор, салбараар нь авч үзвэл: 2014 оны байдлаар /Хувиар харуулав/



Эх сурвалж: Монголбанк, Гадаад секторын тойм /2014.12.11/

Эх сурвалж: Mongolia Investment Climate Statement /2014.07.28/

¹² Ашигт малтмалын тухай хууль, шинэчилсэн найруулга, 2014 оны 7-р сарын 1

Дээрх хөрөнгө оруулагч улсуудаас БНХАУ, Сингапур, Япон, АНУ-ын ГШХО нэмэгдсэн бол бусад орнуудаас оруулсан ГШХО буурсан үзүүлэлттэй байна¹³. Мөн хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг уул уурхай, олборлолт, газрын тос, худалдаа, нийтийн хоолны салбар эзэлж байна. Хөрөнгө оруулалтын тал дээр монгол улс хөрш орнуудтайгаа харилцахаас гадна гуравдагч хөрш улсуудтай харилцаж байгаа нь улс төрийн хувьд онцгой ач холбогдолтой.

Гадаадын хөрөнгө оруулагчид аливаа хөнгөлөлт, урамшуулалт гэхээсээ илүүтэй улс төрийн тогтвортой орчинг чухалчиддаг. Энэ хандлага том, жижиг гэлтгүй гадаад түншүүдтэй хамтран ажилладаг субъект бүрт тохиолддог асуудал.

Монгол улсад бизнес эрхлэхэд тулгарах "топ 10" бэрхшээлийг Invest policy review Mongolia тайланд харуулсан байна. Үнд, мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй 17,9%, засгийн газрын үр ашиггүй хүнд суртал 14,9%, дэл бүтсийн хангамж хангалтгүй 11,3%, авлига 9,2%, инфляци 8%, гадаадын валютын зохицуулалт 6,8%, улс төрийн тогтвортой байдал 6,4%, санхүүжилт авах 5,8%, ажиллах хүчиний этик муу 5,7%, засгийн газрын тогтвортой байдал 3,5%¹⁴ байна гэж харуулжээ. Эдгээрийн ихэнх нь улс төрийн орчинтой холбоотой байгаа нь харагдаж байна.

1993 онд батлагдсан "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хууль нь Монгол улсын төр засаг гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг таатай, тогтвортой байлгах, хөрөнгө оруулалтын горим, зохицуулалтад илүү таатай нөхцлийг олгох бодлогыг тууштай баримталдаг улс гэдгийг батлан харуулдаг эрх зүйн баримт, акт байсан. Монгол улс Гадаадын хөрөнгө оруулалтын төрөлжсөн хуультай орнуудын нэг байсан. Энэ нь Монгол улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, төрийн зохицуулалтын нэг давуу тал болж байлаа. Мөн энэ хуулийн хүрээнд Монгол улсад 20 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс доошигүй хэмжээний хөрөнгө оруулах хөрөнгө оруулагч хүсэлт гаргавал түүний үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах эрхзүйн баталгаа болгож Монгол улсын засгийн газрыг төлөөлж татварын бодлогын асуудал эрхэлсэн гишүүн уг хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээг 10-15 жилийн хугацаатай байгуулах зохицуулалт үйлчилж байсан. Гэтэл энэ хуулийг 2013 оны 11-р сарын 1-ээс эхлэн хүчингүй болсонд тооцсон. Гадаадын хөрөнгө оруулагчдыг хамгаалах, тэдэнд тогтвортой байдлыг бий болгох гэх мэт асуудлыг угүй хийсэн нь улс төр, улс төрийн бодлоготой холбоотой.

2012 оны УИХ-ын сонгуулиас хойш хоёр ч засгийн газар солигдож, шинэ засгийн газар ээлжит бодлогоо хэрэгжүүлэх гэж байна. Өмнөх засгийн газрын богино хугацаанд хэрэгжүүлсэн ажил дараагийн засаглалын шинэ ажлаар солигдох нь хөрөнгө оруулалтыг татахад их саад бодлог. Монгол улсад улс төрийн бодлогын "залгамж холбоо" үгүйлэгдэж байна. Улс төрийн орчин, улс төрийн тогтвортой байдал ГШХО-д шууд нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, улс төрийн бодлого хоорондоо уялдаа холбоогүй. үргэлжлэн явах залгамж халаагүй, улс төрийн тогтвортой байдал зэрэг нь ГШХО-г буурахад нөлөөлдөг гол хүчин зүйл юм. Хөрөнгө оруулалтын хэрэгжих хугацаа. түүнээс гарах ашиг нь урт хугацаанд хэрэгжих үйл ажиллагаа учраас хөрөнгө оруулагчдад урт хугацааны тогтвортой бодлого, бодлогын хэрэгжилт маш чухал.

ГШХО нь нэг орноос нөгөө орон руу гүйвах энгийн нэг мөнгөний ургсал биш, түүнтэй хамт үргэлж шинэ технологи, шалгарсан менежментийн арга барил, маркетингийн ноу-хау, нарийн мэргэшсэн мэргэжилтэнт дагуулж ирдэгийн дээр эдгээр нь тухайн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа улсын эдийн засагт чухал ач холбогдолтой байдаг. Тийм учраас бил ГШХО-г дэмжин аль болох нэмэгдүүлэх тал тээр энхаарах хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын дэргэдээ эдийн засагт чухал, ажлын байр, үйлдвэрлэл, худалдаа, худалдан авах чадвар зэрэг олон үзүүлэлт өсч нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдалд зэрэг хандлага бий болно.

Хонгконгд болсон Хөрөнгө оруулалтын бага хурал дээр АНУ-ын Элчин сайд Пайпэр Энн Уинд Кэмбэлл хэлсэн үгэндээ: ...Монгол Улсад хөрөнгө оруулагчдын сонирхлыг татдаг урт хугацааны үндэс суурь цогцоороо байна. Ихээхэн хэмжээний ашигт малтмалын нөөц байсаар байгаа бөгөөд түүнийг хянуур нямбай, ухаалгаар ашиглах юм бол зөвхөн аж ахуй эрхлэгчдээр зогсохгүй

¹³Монгол банк, Гадаад секторын тойм. 2014 оны 3-р улирлын гүйштгэл. 2014 оны 12-р сарын 11

¹⁴United Nations Conference on Trade and Development, UNCTAD, Investment policy review, 2013

Монголын ард иргэд бодит үр шимийг нь хүртэх боломжтой гэж хэлсэн нь цаашид ГШХО-г татах асуудал нь олон талын ач холбогдолтойг төр засагт анхааруулсан үнэтэй зөвлөмж болсон байна. Монгол улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах их боломж байгаа. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын тухай хууль, төрийн институцитай,
- Авлига¹⁵, бизнесийн саад тогторыг тууштай бууруулж буй улс,
- Зах зээлийн тогтолцоотой,
- Ашигт малтмалын нөөцөөрөө дэлхийд тэргүүлэгч¹⁶,
- Өсч буй эдийн засаг¹⁷,
- Дэлхийн хоёр том эдийн засгийн дунд оршид газар зүйн байрлал¹⁸,
- Нэг хүнд ногдох газар нутгаараа дэлхийд тэргүүлэгч,
- Татварын хэмжээ бага¹⁹,
- Худалдааны нээлттэй тогтолцоотой²⁰.

/Source: UNCTAD, World Investment Report 20 /гэх мэт.

Хөрөнгө оруулалтын тухай хууль хэрэгжийж эхэлсэнээр хөрөнгө оруулалтыг дэмжих сайшаалтай хэрэг боловч үүнийг илүү нарийвчлалтай, тодорхой болгох ажил бидний өмнө байна. Мөн бид ГШХО-тай холбоотой байнгын үргэлжлэх “залгамж холбоотой” бодлогыг бий болгож, тодорхойлох, ард иргэдээл сурталчилан таниулах, гадаадын хөрөнгө оруулалтын улс төрийн орчныг бүрдүүлэх, тогтвортжуулах, гадаадын хөрөнгө оруулалттай бүс нутгийг байгуулах зэрэг ажлуудыг хийх нь ГШХО-ыг татах таатай нөхцөл бүрдэх юм.

ДҮГНЭЛТ

ГШХО-г татах хамгийн чухал алхамуудын нэг нь улс төрийн тогтвортой орчныг бүрдүүлэх явдал юм. Улс төрийн /засаглалын/ залгамж холбоо бүхий бодлогыг өндөр түвшинд зохион байгуулж урт хугацааны наасжилттай, хэрэгжилтэй бодлого бий болгоход онцгой анхааран ажиллах хэрэгтэй байна. Мөн хууль эрхзүйн хүрээнд асуудлыг нарийвчлан тодорхой зааж хөрөнгө оруулагчдыг татах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хөрөнгө оруулагчдыг урт хугацаанд ашиг олох нөхцлийг бүрдүүлсэн, оруулсан хөрөнгө, техник технологийнхоо үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжоор лангах нь хөрөнгө оруулалтыг татах суурь юм. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт нь хэрэгжих хугацаа ашиг хүртэх бололцоо нь урт хугацаанд хэрэгжих үйл ажиллагаа байдаг учраас хөрөнгө оруулагчдад урт хугацааны тогтвортой бодлого, эдийн засгийн таатай орчин шаардлагатай. ГШХО нь зөвхөн бэлэн мөнгөний үргэлжлэл биш. түүнтэй хамт үргэлж шинэ техник технологи, оновчтой менежментийн /удирдлагын/ арга барил, маркетингийн ноу-хау, нарийн мэргэшсэн мэргэжилтэнг дагуулж ирдэгийн дээр эдгээр нь тухайн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа улсын эдийн засагт чухал ач холбогдолтой. Монгол улсын хувьд ул уурхайг түшсэн хөрөнгө оруулалт давамгай байдалтай байгаа ч бусад салбардуу чиглэсэн хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагааг эрчимжүүлэх хэрэгтэй.

¹⁵ Монголын Авлигын индекс 2013 оны байдлаар 0.65 (Авлига хэмээх сорог үзэгслийн цар хүрээ, хэлбэр, шалтгааны тодорхойлох тооц болон чанарын үзүүлэлтүүдийн иййлбэр цогцыг авлигын индекс гэж ойлгоно) гарсан нь 2011 оныхое Монгол Улс дахь авлигын түвшин 0.02 пунктээр буу рсан.

¹⁶ “Behre Dolbeare” компанийн 2008 онд хийсэн судалгаагаар Монгол улс ашигт малтмалын нөөцөөрөө дэлхийд 10-рт бичигдээн.

¹⁷ Монгол улсын эдийн засгийн есөлт 2014 оны эхний 3-р улирлын байдлаар 7%-ийн есөлттэй байна. /Монгол улсын Үндэсний статистикийн хороо, <http://www.nso.mn/>

¹⁸ БНХАУ, ОХУ гэсэн хоёр том зах зээдэд нэвтрэх боломжийг олгох давуу талтай

¹⁹ Хүн амын орлогын албан татвар 10%, Аж ахуй нэгжийн орлогын албан татвар 10%. Гаалийн татвар 5%, Нэмүү өртөгийн орлогын албан татвар 10% http://investmongolia.com/?page_id=61

²⁰ 1997 оны 1 сарын 29-нд Монгол Улс Дэлхийн Худалдааны байгууллагад албан ёсвор орсон ба үүнтэй холбогдуулан худалдаа, бизнес эрхлэх орчиндго томоохон өөрчлөлтүүдийг хийсэн. Монгол Улсад худалдаа эрхлэхэд ямар нэгэн тусгай зөвлөрэх шаардлагагүй бөгөөд Монгол Улсад бүртгэлтэй бүх хуулийн угзээд гадаад, дотоод худалдаа эрхлэх эрх нээлттэй байдал. http://investmongolia.com/?page_id=238

НОМ ЗҮЙ

1. Ашигт малтмалын тухай хууль, шинэчилсэн найруулга, 2014 оны 7-р сарын 1
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 2006 он
3. Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он
4. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль /хүчингүйд тооцсон/
5. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалт хийх тухай хуулийг 2012 оны 5-р сар. /хүчингүйд тооцсон/
6. З.Бороо, Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, 2008 он
7. Монгол Банк. Гадаад секторын статистикийн III семинар Шууд хөрөнгө оруулалт 2009 он
8. Монгол Банк. Гадаад секторын статистикийн III семинар Шууд хөрөнгө оруулалт 2014 оны 2-р улирлын гүйцэтгэл
9. Монгол банк. Гадаад секторын тойм, 2014 оны 3-р улирлын гүйцэтгэл. 2014 оны 12-р сарын 11
10. Монгол улсын эдийн засгийн тойм, Монгол дахь Дэлхийн Банкны групп, 2013 оны 4-р сар
11. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. 2011 оны 12-р сарын 15
12. U.S. Embassy in Ulaanbaatar Mongolia. 2014 Mongolia Investment Climate Statement. 7/28/2014
13. United Nations Conference on Trade and Development, UNCTAD. Investment policy review. 2013
14. www.supremecourt.mn
15. www.investmongolia.mn
16. <http://www.businessdictionary.com/definition/political-environment.html#i-vz31.hzi!VY.w>, 12/18/2014
17. http://graphics.thomsonreuters.com/gfx/Risks_Mongolia.pdf 12/18/2014
18. <http://info.worldbank.org/governance/wgi/pdf/e147.pdf> 12/15/2014
19. <http://prophecycoal.com/mongolia-is-fast-growing-economy-exists-investment-climate>, 12/17/2014
20. <http://www.nso.mn> 12/16/2014